

2017 ОНЫ “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

2018 оны 02 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Тус газар нь 2017 онд Шилэн дансны тухай хуулийн 8.2 заалт, ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичиг”-ийн хамрах хүрээний 3.2.3.5-д заасны дагуу хуулийн хэрэгжилт болон мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв цаг тухайд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, улирал бүр үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажиллав.

Тус газраас энэ ажлын хүрээнд Сангийн сайдын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай” 2017 оны 13/-2/584 дугаар зөвлөмжийг хүргүүлэн, “Дотоод ажлыг сайжруулах, зардал хэмнэх, төвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх тухай” ТНБД-ын 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 13/30 дугаар зааварлах захидал, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд байршуулах хугацааны графикийн талаар е/13/17/027, мэдээллийн цахим хуудсанд байршуулах зөвлөмжийг Е/13/17/052, мэдээллээ бүрэн байршуулах, нөхөж байршуулах тухай хугацаатай үүрэг даалгавар бүхий Е/13/17/083, Е/13/17/084, Е/13/17/068, Е/13/17/196, Е/13/17/201 нийт 7 цахим шууданг ДТГ-уудад тус тус хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллав.

ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын дагуу мэдээллийг байршуулсан байдлыг 2017 оны жилийн байдлаар дүгнэж үзэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт 87.7 хувийн гүйцэтгэлтэй гарч нийт төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 4 байгууллага, 42 ДТГ-ын цахим тайланг хуулийн хугацаанд илгээсэн болно. Тайлангийн хугацаанд нийт 16 төрлийн давхардсан тоогоор 4922 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд 2385 буюу 51.5 хувь, хугацаа хоцорч 1922 буюу 40.4 хувь, мэдээлэл байршуулаагүй 401 буюу 8,1 хувь гүйцэтгэлтэй байна. /Хавсралт 1/

Мөн энэ хугацаанд Пхеньян ЭСЯ-ны шилэн дансны мэдээллийг суугаа орны интернет хэрэглэх боломжгүйнээс шалтгаалж СЭЗХ-ээр дамжуулан мэдээллийг байршуулж байсан нь хугацаа хоцорч байршуулах мэдээллийн тоо нэмэгдсэн болно.

Тайлант хугацаанд “А” үнэлгээтэй 32 ДТГ, “В” үнэлгээтэй 1, “С” үнэлгээтэй 3, “D” үнэлгээтэй 6 ДТГ байна.

Үүнд: Гавана, Дели, Оттава, Прага, Осака, Хонконг ЕКГ

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байдлыг байгууллага тус бүрээр гаргав. /хавсралт 2/

Санал:

1. 2018 оны тайлант жил эхэлж байгаатай холбогдуулан шилэн дансны цахим хуудсанд аль бүлгийн мэдээлэл оруулаагүй байдалдаа хянаж тавьж, хугацаанд нь мэдээллээ бүрэн байршуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

2. Пхеньян ЭСЯ-ны шилэн дансны мэдээлэл байршуулах асуудлыг суугаа орны интернетийн боломж бүрдсэн цагт байршуулах асуудлыг Сангийн яамны Мэдээлэл технологийн газарт хүсэлт явуулж түр хаалгуулах

3. “Шилэн дансны тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсан тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг зөрчсөн, 2017 оны мэдээ тайлангаа цахим хуудсанд оруулж байршуулаагүй, албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй “D” үнэлгээтэй 6 ДТГ-н тэргүүн, нягтлан бодогч нарт “Төрийн албаны тухай хууль”-ын 26 дугаар зүйл, Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ийн 5.3, д зааснаар хариуцлага тооцох.